

**“ХӨВСГӨЛ ХҮНС” ХУВЬЦААТ КОМПАНИЙ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

2022-04-29

Мөрөн

Хурал: Хөвсгөл аймаг Мөрөн сумын 8-р багт байрлах “Хөвсгөл Хүнс”ХК-ийн өөрийн хурлын зааланд 2022 оны 04-р сарын 29-ны өдрийн 14.00 цагт эхлэв.

Хурлын ирцийг “Хөвсгөл Хүнс” ХКомпанийн ТУЗ-ийн Хурлын дарга Л.Дашцэрэн ирцийг 83.4 хувь байгааг мэдэгдэж хурлыг нээж.

Хурлаар хэлэлцэх асуудлууд, хурлын дэгийг танилцуулав.

- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт
- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг батлах
- Хянан шалгах зөвлөлийн тайлан
- ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- ТУЗ сонгох

Хурлын дарга Л.Дашцэрэн- Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт

Гүйцэтгэх захирал Л.Төмөрбаатар- Компанийн бизнес үйл ажиллагааны тайлан

- Компанийн 2022 оны бизнес төлөвлөгөөг
- ТУЗ-ийг сонгох асуудлыг хэлэлцүүлэв.

Ерөнхий нягтлан бодогч Л.Тэгшбаяр - Хянан шалгах зөвлөлийн тайлан

Хурлын дарга Л.Дашцэрэн - ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв зэрэг асуудлыг хэлэлцүүлж санал хураалт явуулав.

2021 оны жилийн эцэст ашиггүй ажилласан тул ногдол ашиг хувиарлах боломжгүй болсон.

За дээрхи асуудлуудтай холбоотой санал хүсэлт байна уу?

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга Ж.Алтангэрэл- Тооллогын комиссын дүнг танилцуулав.

Хурлын дарга Л.Дашцэрэн- Тооллогын комиссын дүнг үндэслэн тогтоолын төслүүдийг батлуулж уншиж танилцуулав.

Гүйцэтгэх захирал- Л.Төмөрбаатар - 2022 онд компаний хэмжээнд дараах ажлуудыг бизнес төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлж ажиллаж байна.

1. Үйлдвэрлэлийн чанарын хяналтыг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоог нарийн зохион байгуулалтад оруулж, тусгай журманд оруулах.
 2. Бүтээгдэхүүний сав баглаа боодлыг шинэчлэх сайжруулах шинэ өнгө төрхийг бий болгож, багцын бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.
 3. Талх нарийн боовны үйлдвэрлэлийн технологийн шинэчлэлт хийх /орц жорын сонголт /норм, түүхий эд материалын, бүтээгдэхүүний чанарын сайжруулалтыг иж бүрнээр хэрэгжүүлнэ.
 4. Архины шүүлтийг бүрэн шинэчилж евро стандартын шүүлтүүрийг үйлдвэрлэлтэд нэвтрүүлэх.
 5. Нөөшилсөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх нөөшилсөн бүтээгдэхүүний цехийн ашиглалтын түвшинг нэмэгдүүлэх /мах нөөшлөх, ногоо нөөшлөх, хатаах, савлах, утах/ гэх мэт.
 6. Сүү цагаан идээ, байгалын баялаг ашиглах экологийн цэвэр хүнс үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн технологийн арга ажиллагааг боловсронгуй болгох арга хэмжээ авна.
 7. Шинэ нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд таниулах бүх талын арга хэмжээг шат дараатай зохион байгуулах
 8. Талх нарийн боовны цехийн үйлдвэрлэл борлуулалтыг Хөвсгөл аймгийн зах зээлд шинэ шатанд гаргах
 9. Хөвсгөл далайн цэвэр усыг үйлдвэрийн аргаар боловсруулж монгол улсын зах зээлд нэвтрүүлэх.
 10. Компанийн гол нэрийн брэнд бүтээгдэхүүнүүдийг Монгол улсын зах зээлд гаргах.
- Хувицаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 15.30 минутад хаав.

ТАНИЛЦСАН: ТҮЗ-ИЙН ДАРГА  Л.ДАШЦЭРЭН

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ТҮЗ-ИЙН ДАРГА  С.ОТГОНБААТАР